



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/62

Мандалговь

**“Охидын инээмсэглэл” өдөрлөг  
зохион байгуулах тухай**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийг угтан “Охидын инээмсэглэл” өдөрлөгийг зохион байгуулсугай.
2. Өдөрлөг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Өдөрлөгийн үйл ажиллагаанд шаардагдах 683000 (Зургаан зуун наян гурван мянга) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

431190175